

Батлан хамгаалах эрдэм шинжилгээний хүрээлэн болон БНСУ-ын Батлан хамгаалах дүн шинжилгээний хүрээлэн хамтран 2007 оноос хойш жил бүр хоёр талын хамтарсан эрдэм шинжилгээний хурлыг зохион байгуулж ирсэн билээ.

Сүүлийн жилүүдэд Солонгосын хойгийн аюулгүй байдал, улс төрийн орчинд томоохон оорчлолтууд гарч, бус нутгийн улс орнуудын хоорондын яриа хэлэлцээний давтамж нэмэгдэж байна. Эндээс үүдэн олон жилийн турш Зүүн хойд Ази, дэлхийн аюулгүй байдлын зангилаа асуудлуудын нэг байсаар ирсэн Солонгосын хойгийн асуудал эерэгээр шийдэгдэх бодит боломж нэмэгдэж байна гэж олон улсын шинжээчид дүгнэж байна.

Иймд Солонгосын хойгийн асуудлыг шийдвэрлэхэд бус нутгийн орнуудын гадаад бодлого болон тэдгээрийн хоорондын харилцааны Солонгосын хойгийн асуудлыг шийдвэрлэхэд үзүүлэх нолооллийг судлах, тэр дундаа Монгол Улс-БНСУ-ын харилцааны үзүүлэх нолооллийг судлах нь чухал ач холбогдолтой хэмээн үзэж 2019 оны 05 дугаар сарын 20-22-ны одор “Солонгосын хойгийн асуудал болон БНСУ-Монгол улсын харилцаа” сэдвээр хоёр талын хамтарсан ээлжит хурлаа ҮБХИС-ийн Жанжин танхимд зохион байгууллаа. Хурлын үеэр нийт 4 илтгэл хэлэлцүүлсэн ба батлан хамгаалах салбар хоорондын хамтын ажиллагааг оргожүүлэн хөгжүүлэх, тодорхой хувь нэмэр оруулах, бус нутгийн аюулгүй байдал зэрэг асуудлаар санал солилцлоо.

